


МОНГОЛЧУУДЫН НОМ БИЧГИЙН ХЭРЭГСЛҮҮДИЙГ МЭДЭХ

ᠮᠣᠩᠭᠣᠯᠴᠢᠳᠤᠨ
ᠨᠣᠮᠪᠢᠴᠭᠢᠨ
ᠬᠡᠷᠡᠭᠰᠢᠯᠤᠳᠢᠶᠢᠭᠢᠮᠡᠳᠡᠬᠤ



ᠮᠣᠩᠭᠣᠯᠴᠢᠳᠤᠨ
ᠨᠣᠮᠪᠢᠴᠭᠢᠨ
ᠬᠡᠷᠡᠭᠰᠢᠯᠤᠳᠢᠶᠢᠭᠢᠮᠡᠳᠡᠬᠤ



ХИЧЭЭЛ 3-2

ТУЛГУУР ОЙЛГОЛТ



Бичгийн дөрвөн эрдэнэд юу юу орох вэ?

БИЙР: Үс хялгасыг багцлан ишинд суулгаж, бичиг бичих, зураг зурахад зориулсан хэрэглэл.

ЯНТАЙ: Бэх будаг зуурах сав

БЭХ: Бичих зурахад хэрэглэх шахмал болон шингэн будаг

ЦААС: Химийн болон механик боловсруулалтаар бичих, зурах, хэвлэх, хулдах зүйлд хэрэглэхээр хийсэн нимгэн хуудсан эд.



Түлхүүр үгийн тайлбар

Бар – Төвөд хэлний бар “модон самбар” гэсэн үг. Модон самбарт үг сийлэн дарах үйлийг барлах гэнэ.

Бархан – барын ном хийх газар

“Бичих туурвих хүмүүний жаргалан гэвээс бийр бэхсийн үлдээх мөр бөлгөө” Дандар аграмба

Үйл ажил, уран бүтээлээ хийж, бүтээж дуусгах: **ном туурвих** (том хэмжээний ном зохиох, бичих), **уран бүтээл туурвих** (ямар нэг томоохон уран бүтээл хийх). Эх сурвалж: Монгол хэлний тайлбар толь

1886 онд байгуулагдсан Утга зохиол болон урлагийн ажлыг хамгаалах тухай Бернийн конвенц нь зохиогчийн эрхийг хамгаалах эрх зүйн суурь үндсийг тавьсан. Монгол Улсын хувьд 1993 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Зохиогчийн эрхийн тухай хуулийг баталж, улмаар Бернийн конвенцид 1997 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр нэгдэн орсон байна.

БИЧЭЭЧИЙН ЗЭРЭГ ДЭВ



ОНЬСОГО ТААЦГААЯ

1. Гүн худгийн ус хар
Гүрвэл могойн хэл хар
Гүйгээд гарсан мөр нь хар

2. Цагаан газрыг харлуулдаг
Чадамгай мэргэн ухаантай
Бүдүүн нарийн биетэй ч
Бүгд ижил үүрэг гүйцэтгэнэ

3. Гурван нөхрөөр түшүүлдэг
Гуа нарийн биетэй
Улсын хэргийг товчилдог
Уран сайхан хошуутай
Цангаг ангаг зантай
Цагаан газар явдалтай

4. Өөрөө уншдаггүй мөртлөө
Өврөөрөө дүүрэн номтой явдаг

БАРЫН ТӨРӨЛ

Хүрэл бар

Чулуун бар

Зэс бар

Модон бар



Хорголжин бар-номын үсгийг хуудас хуудсаар нь өрдөг. 20-р зуунаас хэрэглэсэн.

Алдаатай сийлсэн бол баллаж болохгүй
Нягт нямбай зан чанар эзэмших
Урлахуй ухааны нэг аргыг мэдэх

Сурах бичиг 115 хуудасны
дасгал ажиллах
Кирилл үсгээр тэмдэглэх



Ард түмний билэг авъяас, мэдлэг, туршлага, эрдэм ухаан, ур чадварын тодорхой илэрхийлэл болон биет бусаар өвлөгдөн уламжлагдаж ирсэн түүх, угсаатны судлал, ардын билэг, зан үйл, ур хийц, арга барил, дэг сургууль, урлаг, шинжлэх ухааны ач холбогдол бүхий оюуны соёлын үнэт зүйлийг соёлын биет бус өв гэнэ.

- Соёлын өвийн тухайд ЮНЕСКО нь тухайн ард түмэн эсвэл хамт олны уран бүтээлчид, архитекторууд, хөгжимчид, зохиолчид, ухаалаг хүмүүсийн бүтээлүүдийн цогц гэж тодорхойлдог.
- Эдгээр соёлын бүтээгдэхүүнд амьдралын утга учрыг өгдөг үл мэдэгдэх бүтээл, үнэт зүйлс, өөрөөр хэлбэл тухайн хот суурин газрын оршин суугчдын бүтээл туурвисан материаллаг ба материаллаг бус бараа багтдаг.
- Эдгээр соёлын үнэт зүйлсийн жишээ бол хэл яриа, зан үйл, итгэл үнэмшил, түүхэн дурсгалт газар, хөшөө дурсгал, уран зохиол, урлагийн бүтээл, архив, номын сан юм.

ДЭЛХИЙН СОЁЛЫН БИЕТ ӨВД БҮРТГЭГДСЭН МОНГОЛ НОМ СУДРЫГ МЭДЭХ

- XIX зууны сүүлээр Богд хан уулын өмнө орших Манзуширийн хийдэд Дагва тэргүүтэй дархчууд сүсэгтэн олны хандиваар бүтээжээ. Уг хийдэд Манзушири хутагт Цэрэндорж эзэмшиж байсныг хожим Богд хааны номын сангаар дамжуулан 1924 онд Үндэсний номын санд шилжүүлжээ.
- Мөнгөн хуудсыг хөөмөлдөн алтдаж, найман мөрөөр бичсэн, нийт 1460 лан буюу 52 кг 560 гр алт, мөнгө орсон. Хуудас бүрийг суман модон хавтсанд суулгаж, судрын 50 орчим хуудсанд бурхадын дүрийг товойлгон бүтээсэн бөгөөд ханд дагинисыг хатгаж урласан торгон хөшигтэй.
- Монгол Улсын Засгийн Газрын 1995 оны 241-р тогтоолоор түүх соёлын “ХОСГҮЙ ҮНЭТ” өвд бүртгэжээ.

МӨНГӨН САНДУЙН ЖҮД /Нууц хураангуйн үндэс/



https://www.facebook.com/watch/live/?v=1045869102534488&ref=watch_permalink

АЛТАН УСГИЙН ЖАДАМБА СУДРЫГ ЮНЕСКО-Д


БҮРТГҮҮЛЭХЭЭР ХҮСЭЛТ ГАРГАЖЭЭ



"Эртний хаадын үндэслэсэн төрт ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч оршвой"

- Лу.Алтан товчийг ЮНЕСКО-ийн Дэлхийн дурсамж хөтөлбөрт 2011 онд бүртгэсэн.
- XVII зууны үед амьдарч байсан монголын эрдэмтэн гүүш Лувсанданзан Чингис хаанаас Лигдэн хаан хүртэлх үеийг хамран өгүүлсэн "Эртний хаадын үндэслэсэн төрт ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч оршвой" хэмээх шастирыг туурвин зохиожээ. 1651 онд зохиогдсон
- Лу.Алтан товчид Монголын нууц товчооны 282 зүйлээс 233 зүйл нь хэвээрээ байхаас гадна Монголын нууц товчоонд байхгүй олон нэмэлт бүлэг байх тул Монголын нууц товчооны монгол эхийн нэг хувилбар гэж эрдэмтэд үздэг бөгөөд Монголын төдийгүй Дэлхийн хэмжээний үнэ цэнэтэй бүтээл юм. Алтан товчийн жинхэнэ эх зохиол болох хулсан үзгийн бичмэлийг 1926 онд Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн анхны дарга асан Онгодын Жамъян гүн Дорнод аймгийн Баянтүмэн хошууны еншиезбүү овгийн тайж Дарь гэдэг хүнээс олж авснаар Лу.Алтан товч монголын түүх, уран зохиолын судалгааны ховор чухал, үнэт дурсгал болон мөнхөрчээ.

ЛУВСАНДАНЗАН “АЛТАН ТОВЧ”



Ганжуур бол буддын шашны эрдэнэсийн сан ажээ. Хүн ёс зүйтэй, хүнлэг чанартай, дотроосоо хөгжиж, зөв зохистой боловсорч чадвал бусдад буян түгээж байгаа хэрэг хэмээн өгүүлжээ. 9 эрдэнээр үсэг мөр сэлгүүлэн хэвлэжээ. Цаасны хэмжээ 16.5*70.5 см, эх бичгийн хэмжээ нь 12*50 см, Ганжуур бол бурхан багшийн амаараа айлдсан сургаал юм. Ганжуур нь монгол хэл дээр 113 боть байдаг.

Данжуур судар нь Ганжуур сургаалийн тайлбар юм. Сударт амьдран буй орчноо танин мэдэж, зөв үйл хийн зохицож амьдрах тухай сонирхолтой сургаал номлолууд байдаг. юм. Данжуур нь 226 боть судар юм. Данжуурыг 1742-1749 онд Бээжинд 226 ботиор барлажээ.



МОНГОЛЧУУДЫН НОМЫН ӨВ СОЁЛ СЭДВИЙН ДҮГНЭЛТ

1. Би монголчуудын номын өв соёлыг судалж байгаадаа сэтгэл хангалуун байдаг.
2. Ёс журамтай, ёс суртахуунтай хүн болохын тулд бичиг номыг дээдлэн суралцах учиртай гэж боддог.
3. Ном бол монгол хүн бүрийн хамгийн эрхэм нандин үнэт зүйл мөн.
4. Монгол үндэсний бичиг үсгүүдийн талаар судлах нь тийм ч ач холбогдолтой биш гэж бодож байна.
5. Монгол хүн бүр монгол бичгээр бичиж, уншиж чаддаг байх ёстой.
6. Монгол бичиг нь монголчуудын сүлд хийморийн бэлгэдэл мөн гэдэгт би итгэдэг.
7. Монгол бичигт суралцах нь миний хувьд маш чухал.
8. Би монгол бичгээр бичиж, уншиж сурсандаа маш их баяртай байна.
9. Монгол бичгээр уншиж бичих нь миний дуртай зүйлийн нэг юм.
10. Би монгол бичиг, номын өв соёлоороо бахархдаг.
11. Би монгол бичиг, өв соёлоо өөрөө сураад зогсохгүй бусдад түгээж заан сургахыг хичээдэг.
12. Монгол бичгийг сурахад надад хэцүү санагддаг.
13. Би монгол бичгээр уншиж бичихдээ тийм ч дуртай байдаггүй.
14. Монгол бичгийг хүн бүр заавал сурах шаардлагагүй гэж бодож байна.
15. Би монгол бичигт өөрийгөө дайчлан шамдан суралцдаг.
16. Би ном, дэвтэр, үзэг харандаа зэрэг бичгийн хэрэгслээ ариг гамтай хэрэглэдэг.
17. Би дэвтэр, ном, үзэг харандаа зэрэг бичгийн хэрэгслээ хаа хамаагүй газар тавьдаггүй.
18. Би хэн нэгэн хүнд ном, бичиг зэргийг өгөхдөө заавал толгой талаар нь харуулж өгдөг.
19. Би монгол бичиг, өв соёлоосоо маш сайн суралцаж чадна.
20. Ном бичгийг үзэж байгаад дэлгээтэй орхих нь буруу зүйл биш.
21. Би ном бичигтэй холбоотой цээр ёсыг тэр болгон хэрэгжүүлээд байдаггүй.
22. Монгол үндэсний бичиг үсгийн талаар уншиж судлах нь надад уйтгартай, залхмаар байдаг.
23. Би монголчуудын номын өв соёлын талаар цаашид үргэлжлүүлэн судлахыг хүсэж байна.

- Үнэлгээний тайлбар

4-Бүрэн санал нийлж байна

3-Санал нийлж байна

2-Зарим талаар санал нийлж байна

1-Санал бараг нийлэхгүй байна

0-Санал огт нийлэхгүй байна